



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 635

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.5 дахь заалт, Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны "Хөрөнгө эзэмшүүлэх тухай" 102 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөрөнгөөр бий болсон нийт 72,000,000.00 (далан хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Баян-Өлгий аймгийн Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран, Баян-Өлгий аймгийн Автотээврийн төвийн захирал Т.Сайдолда нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ГАВАА

0002671

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
 6.35 дугаар тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Баян-Өлгий аймгийн
 Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэм жих нэгж	тоо шир хэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13 дугаар багт байрлалтай 72 м2 талбайтай албан ажлын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	ш	1	72,000,000.00	72,000,000.00
НИЙТ			1		72,000,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)		72,000,000.00 (далан хоёр сая)